

УРАД АЙМГИЙН БҮРЭЛДЭЛ БА АМАН ЯРИАНД НҮҮДЛИЙН ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Чин Хе, магистр, ӨМҮИС

Abstract

In the early 17th century, the Mongolian tribes lived in the north and west of Hingan Mountains, from the Hulunbeir Grassland to the lower reaches of the Herlun River. Among them were the offspring of the Chinggis Han's brothers including Arhorchin, Urad, Moomingyan, Dorbed, Isusod, Ongniyud, Abaga, Abaganar and Khalkha. The Urad tribe was the people of Habutu Hasar, Chinggis Han's second brother. They moved from Hulunbeir grassland to Muni mountain duo to the long historical process and population growth. In the earlier 17th century from back, right body of great Khyangan, Hulunbeir to Plateau Herlen river downstream there were Mongolian provinces. Including, Including, Genghis Khan's siblings include nationals khoichis Back Horchin, Urad, Muumyangan and four children, Isüd, the Onggi, aunt and uncle, and domestic and foreign government Khalkh class group. Under the influence of different culture and language, they formed special characteristics in their language. This paper researches generally why all nations of Mongolian has different pronunciation and language. Therefore in that time what laws and prohibitions were valid in Mongolia. Every tribe had own culture, pronunciation sometimes different language, laws, prohibitions, tradition and rituals. All of these had own character. So in this research it will be explained. Also on the origin and development of Urad spoken language based on the tribe's formation and its nomadic culture. Accordingly Mongolian traditional nomadic culture how did affect to "Urad" tribe's conversation. And it discusses the source of the tribe's name "Urad" and its formation, nomadic history and influence on their spoken language systemically.

Түлхүүр үг

Урад аймаг, бүрэлдэл, нүүдэл, аман яриа

Нэг. “Урад” гэх нэрийн үүсэл гарал хийгээд урад аймгийн бүрэлдэл

1. Урад аймаг нь хэдий үеэс эхлэн бүрэлдэж оршин байсан тухай түүхэн тэмдэглэл ховор, хэдий ч уг асуудлаар хэд хэдэн ялгаатай тайлбарлаж байдаг. Нэн түрүүнд “Урад” гэх үгийн авианы хувирлаас үүсэлтэй холбоотой үзэл байна. Чингис хааны дүү Хавт Хасарын дагуулсан цэрэг анги нь дайн байлдаанд хэзээд хошуучлан, урьдаар туршуулын цэрэг анги нь дайсны байдлыг тагнан улбаатай цэрэг анги хожим нь Урьд аймаг болсон гэдэг. Аажмаар авианы хувиралт гарч “Урад” аймаг гэх болжээ. Энэ талаар баримт нотолгоо ирээгүй байдаг. Дараагийнх нь Уругуд аймгаас үүсэлтэй гэх үзэл байна. “Монголын нууц товчоо”-ны 43-46 хэсэгт тэмдэглэснээр Бодончар мунхагийн хөвүүн Хабичи баатар, Хабичи баатрын хөвүүн Манан Тодун, түүний хөвүүн Хачи хүлэг, Хачин, Хачигу, Хачула, Хачигун, Харандай, Начин баатар, Начин баатрын хөвүүн нь Уругудай байж, Уругуд овогтны дээдс болсон байна. Урад аймаг бол Хавт Хасарын хойчис болох нь тодорхой. Хавт Хасар бол Манан Тодуны хөвгүүн Хачи Хүлэгийн хойчис болно. Иймээс “Уругуд” овогтон ба “Урад” аймгийг адил нэрээр хэлэх нь түүхэн үнэнтэй нийцэхгүй. Чингис хаан ба Жамухын хооронд

болсон “Арван гурван хүрээний дайн”-ы дараа Уругуд аймгийн ахлагч Зүрчидэй өөрийн харьяат аймгаа дагуулан Чингис хааныг түшсэн гэдэг. “Хорчин товчоо”-нд “Эрдэнийн товч”-оос ишилж, Хорчины баатар Шигүшидэй Онг “Уругуд (урхуд, ургууд)-ын баатар Шигүшидэй гэж бичсэн нь хэрэг дээрээ Урадыг уругуд, урхуд, ургууд гэж ташаа бичсэн юм. Иймээс Урад нь нэлээд эртнээс хорчин түмний харьяат отог болно гэжээ (Хурц, Чэн Мин, 2001, х.13, 36, 37, 49, 129, 191, 76). Хавт Хасарын арван нэгдүгээр үеийн ач баатар Шигүшидэйг Урад аймгийн хүн гэж үзсэн байна. Тэгвэл баатар Шигүшидэйн Урад аймгийн хүн болохыг бусад түүхэн сурвалж бичгээс олж харахгүй байна.

2. “Эрдэнийн товч” дахь энэхүү нэг баримт жишээгээр баатар Шигүшидэйг Урад аймгийн хүн гэж хэлэх нь баттай биш юм. Уругуд, Мангуд аймаг бол Чингис хааны дайн байлдаанд хошуучилж явсан хүчирхэг хоёр аймаг болно. Чингис хаан Ван ханыг дайлах дайнд Уругудын Зүрчидэй, Мангудын Хуйлдар манлайлж, дайны ялалтыг олсон нь Чингис хааны цэргийн хамгийн баатарлаг хоёр жанжин, хүчирхэг хоёр аймаг болохыг харуулж байжээ. “Эрдэнийн

товч"-д "Уругуд (Урхууд, Ургууд)-ын баатар Шигүшидэй" гэж гардаг нь Шигүшидэйн баатар хүчийг улам илүү товойлгож байсан байх. Бас нэг үзэл нь "уран" гэх үгэнд олон тооны дагавар "д" залгаж үүсжээ. Нэлээд эрдэмтэд уг үзлийг зөвшөөрч байна. "д" дагавар нь эртний монгол овог аймгийн нэр бүтээх үүрэгтэй байжээ. Жишээлбэл: "Бэлгүнүд, Бүгүнүд, Жүгүрөйд, Мангуд, Уругуд, Тайчууд, Бэсүүд, Хонгирад" гэх мэт. Иймээс Урад нь монголын эртний овог аймгаа нэрлэх заншилтай шууд холбоотой. Чингис хааны их нэгдэл ба гадагш эзэрхэх дайнд олон уран дархан хүмүүсээр гэр тэрэг, эдлэл хэрэгсэл хийлгэж жич, цэргийн зэр зэвсэг хийхийг шаардана. Эдгээр хүмүүс нь Урад аймгийн анхны бүрдэл байж, монголын эл төрд дутагдаж болшгүй чухал үйлдэл үзүүлсээр иржээ. Өгөдэй, хаан суурийг залгамжлаад гааль татварын дүрмийг эхлэн тогтоожээ. "Хятад хүн мөнгө, торго, амуу будаа тушааж, ... урад дархдуудаас бусдыг эр, эм гэж ялгалгүйгээр, жилд хотын арднэг бүрээс хорин таван лан, үхэр, хонины гааль тавин лан, хөдөөгийн тариачдаас зуун лан, амуу будаа бол түүний олон цөөнийг ялгахгүйгээр өрх бүрээс жилд дөрвөн дан, олон замын онгоцон тээвэр зөөвөрлөгчдөөс жил бүр хоёр түмэн лан мөнгө татварладаг..." хэмээжээ (Хар Татаарын хэргийн товч, х.91)

"Урад" гэх үг аймгийн нэрээр хамгийн анх дурдагдсан нь Чингис хааны дүү Хавт Хасарын арван дөрөвдүгээр үеийн ач Бурхай Урад аймгийг ноёлж, Хөлөн Буйр нутгаар нүүдэллэн малжиж байсан үе болно. Үүнд, Бурхай Хавт Хасарын хэддүгээр үеийн ач болох нь эрдэмтдийн өгүүлэл, зохиолд харилцан адилгүй тэмдэглэгджээ. Чимэддорж "Урад аймгийн нүүдлийн шинжлэлт" гэх өгүүлэлдээ Чингис хааны дүү Хавт Хасарын арван тавдугаар үеийн ач Бурхай гэж, Б.Мөнх "Урадын баруун гүнгийн хошууны орчин үеийн ардын дууны тухай" гэх өгүүлэлдээ мөн Хасар богдын арван тавдугаар үеийн ач болох Бурхай ноён гэж, "Хорчин товчоо"-нд "Илтгэл шастир"-аас ишилж, Хавт Хасарын арван дөрөвдүгээр үеийн ач Түмэй Заяач гурван хөвүүнтэй гэж, Бурхайг Хавт Хасарын арван тавдугаар үе гэсэн байна. Жияан Ген Шиюүн "Хорчин аман аялгууны бүрэлдэл, хөгжлийн тухай судлал" гэх зохиолдоо мөн Хавт Хасарын арван дөрөвдүгээр үеийн ач Түмэй Заяачийн отгон хөвүүн Бурхай нь Хөлөн Буйрд малжин, харьяат аймгаа "Урад" гэсэн байв. Энд анхаарууштай нь Бурхай бол Урад аймгийн ноёлогч болохоос биш, анх "Урад" гэж нэрлэсэн хүн биш. Хамгийн наад захдаа Хорчин түмний үед Зүүн гарын долоон отгийн нэг нь Урад аймаг байж, энэ нь Бурхайн өвөг Чи Унг Булунайн үе болно.

Иүй Жи Ейн доктор цол хамгаалах өгүүлэлдээ Хасарын арван гуравдугаар үеийн ач Түмэй Заяачийн ахмад хөвгүүн Хүймөнх Хөлөн Буйр нутгаасаа урагшилж, Нонмөрөн дагуу малжин байхад хоёрдугаар хөвгүүн Багун ноён (Ар Хорчин ба дөрвөн хүүхдийн дээдэс) ба гуравдугаар хөвүүн Бурхай (Урад аймгийн дээдэс) мөн Хөлөн Буйр нутагтаа үлдэж, малжиж амьдарч байжээ. Үүнээс үзвэл Бурхай бол Хавт Хасарын арван дөрөвдүгээр үеийн ач байж таарна.

Н.Хасбагана, Цэцэнтийн найруулан зохиосон "Манжийн ноёлол доорх Монголчууд" гэх зохиолд Хасараас улирч, арван гуравдугаар үеийн Түмэй Заяач хүрэв гэжээ. Бурхай бол Түмэй Заяачийн гуравдугаар хөвүүн болохоор Хасарын арван дөрөвдүгээр үеийн ач болно. Энэхүү байдалд чиглүүлж доор Хавт Хасараас Бурхай хүртэлх шууд үеийн залгамжийг Оюунбилиг, Балжиннямын "Түшээт хан Уурын намтар" гэх номын ард дагалдуулсан хүснэгт ба "元史" -аас жагсааж тодруулъя (元史, х.2710).

Хасарын (нэгдүгээр) хөвүүн Есүнг (хоёрдугаар), Есүнгийн хөвгүүн Шигтүр (гуравдугаар), Шигтүрийн хөвүүн Хонхор (дөрөвдүгээр, 1307 онд Шигтүрийн хөвүүн Бабуша хамгийн анх ЧиУн өргөмжлөгджээ), Хонхорын хөвүүн Иүй Лүн Төмөр (тавдугаар), Иүй Лүн Төмөрийн хүү Чи Ун Ёлтөмөр (зургадугаар), "Хорчин товчоо"-нд Өрөгтөмөр гэж буруу бичсэн байна). ЧиУн Ёлтөмөрийн хөвүүн Чи Ун Ширамун (долдугаар), Чи Ун Ширамун хөвүүн Агсагалдай (наймдугаар), Агсагалдайн хөвүүн Аругтөмөр (есдүгээр), Аругтөмөрийн Адилиг (аравдугаар), Адилигийн хүү Шигүшидэй баатар (арван нэгдүгээр), Шигүшидэй баатрын хөвүүн Чи Ун Булуни (арван хоёрдугаар), Чи Ун Булунийн хөвүүн Түмэй Заяач (арван гуравдугаар), Түмэй Заяачийн хөвүүн Бурхай (арван дөрөвдүгээр) болно. Үүнээс бид Бурхай бол Хавт Хасарын арван дөрөвдүгээр үеийн ач болохыг тов тодорхой мэдэж болно. Тодорхойлох нь: Жан Дай Иүидоктор цол хамгаалах өгүүлэл болох "元史。诸王表" 补证及部分诸王研究(内蒙古大学2008 届博士学位论文)"-д Иүй Лүн Төмөр ба Ёлтөмөрийг нэг хүн гэж үзсэн байна. Үүнийг цаашид түүхэн баримтаар нотлон батлах чухалтай. Бурхай таван хүүтэй. Ахмад хүү нь Лайгаа, хоёрдугаар хүү нь Буянху, гуравдугаар хүү нь Арсаху, дөтгөөр хүү нь Бүрүтү, тавдугаар хүү нь Барасай болой. Хожим нь Урадыг гурван хэсэг хуваарилан захирах үед Бурхайн ахмад хүү Лайгаан ач Омбу, Барасайн хоёрдугаар хүү Ханьсын ач Сэрэн хийгээд тавдугаар хүү Ханидай Бинтүгийн хөвүүн Дуба нар Урад аймгийг зүүн, баруун, дунд гэж хуваан захирч байжээ (Зарлигаар тогтоосон гадаад Монгол хотон аймгийн ван гүнгийн илтгэл шастир", 41-р боть).

Уламжлалт Урад хуримын “Ерөөл”-д хүүхэн талын хэлмэрч үүд даран, ирсэн ургаас

“... Уг удам хаагуур вэ?

Удам садан хэнийх вэ?

Төв нутаг хаагуур вэ?

Төрөл удам хэнийх вэ?” гэхэд хүргэн талын хэлмэрч өгүүллрүүн:

“Уг нутаг Хөлөн Буйр

Удам садан Бурхай засаг гурван гүн

Төв нутаг Хөлөн Буйр

Төрөл удам Хавт Хасарын үр

Эдүгээ хан Моны өвөрт гэж хариулахад хүүхэн талын хэлмэрчээс “Морилон саатаж ирэхдээ, аль төрийн аль хааны, аль дугаар онд, аль жил, аль сард, ямар учир шалтгаанаар, энд саатаж ирсэн бэ? гэж асуувал, “Эээр засагчийн зургаадугаар онд, ахай гурвуулаа авлан мордож, хан Моньг хаяалж, хатан голыг хөвөөлж, хамтлан явж, дайснаа дарж, дархан цолыг олж...” гэж хариулдаг (Ваанжил, 1989). Энэ нь Урад аймгийн түүхэн улбааг харуулж байгаа юм. Учир нь ардын аман уламжлалын түүх бол зохих байдлаар түүхэн үнэн бодит байдлыг тусгаснаар барахгүй эрдэм шинжилгээний үнэт эх сурвалж болдог.

Хоёр. Урад аймгийн нүүдэл

XVII зууны эхээр их Хянгaн давааны хойд бие, баруун бие, Хөлөн Буйрын тал нутгаас Хэрлэн голын доод урсгал дагуух нутгаар арын монгол аймгууд нутаглан амьдарч байжээ. Үүнд, Чингис хааны дүү нарынх нь харьяат хойчис болох Ар Хорчин, Урад, Муумянган, Дөрвөн хүүхэд, Исүд, Онгинууд, Авга, Авга нар, дотоод, гадаад засаг халх зэрэг аймаг бүлэг багтана. Эдгээр аймаг бүлэг нь Их Хянгaн давааны ард нутагладгаас Ар Монгол аймаг гэжээ. 1604 онд Лигдэн Монголын хаан орыг залгамжилж, Монголын эл аймгийг зэвсэгт хүчээр нэгтгэх гэхэд эл аймгийнхан эсэргүүцэж, өөрийн ханыг өргөмжилснөөр Лигдэн хан нь зөвхөн Цахар аймгийн хаан төдий болжээ. Энэ үед Мин улс ба Монгол төртэй эсэргүүцэлдсэн Зүрчин аймгийн Нурхач 1616 онд Айшин гүрэн /манж үг, монгол хэлэн дэх утга нь “Алтан улс”, түүхэн дэх Зүрчин аймгийн “Алтан улс”-тай ялгахын тулд бас “Хойд Алтан улс” гэдэг)-ийг байгуулж, Монголын эл аймгийг биедээ татан, Лигдэн хааныг ганцаардуулж, Мин улстай дайтжээ. Энэхүү төрийн бодлогын дүнд 1624 онд манж нь нун хорчинтой холбоо байгуулан 1626 онд нун хорчины ахлагч Уубаныг Түшээт хан өргөмжилж, ураг барилдан Айшин гүрэн ба хорчины хоорондох харьцаагаа нягтруулжээ. Дахин өвөр таван халхын Зарууд, Баарин, Үжээд, Баяд, Хонгирад зэрэг аймаг Айшин гүрний илбин дагуулах ба сүрдүүлгийн доор бууж өгчээ. 1627 онд Лигдэн хаан Манжийн

дарамт доор баруун зүг нүүдэллэхийг дагалдан Харчин түмэн нь задран 1628 онд мөн Манжийг түшжээ. Ийнхүү Хянгaн даваанаас өмнөх олонх аймаг бүлэг Айшин гүрэнтэй хойно, өмнө холбоо байгуулсан байна. Айшин гүрний дараах бодлого нь даруй Хянгaн давааны ард байгаа Арын Монгол аймагт чиглэж, аргадан татах төрийн бодлогоо үргэлжлэн хэрэгжүүлжээ. Энэ үеийн арын Монгол аймаг нь тухайн улс төрийн байдалд татагдан аажмаар өмнөш нутагласан байжээ.

Тэнгэрийн Цэцний тавдугаар онд (1631 он) Урад аймаг нь Айшин гүрнийг түших зам зуур Илжиг зоригтын хөвгүүн ба Жалайдын өдөөн хатгалт дор Хянгaн давааны ар луу дахин буцсан байна. Үүнийг Манжийн хаан сонсоод Ар Хорчин аймгийн зайсан Далай Чүнхүр ба Дөрвөн хүүхэд аймгийн тайж Сэнгэд зарлиг болж, тэр хоёрыг хүн томилж, Урад аймгийг ятган буцааж авчрах хэрэгтэй гэв. Энэхүү зарлигийн бичгийг “Дундад улсын түүхийн нэгдүгээр архив”-т хадгалж байна. Зарлигийн бичиг дэх 18-р зүйлд нь “Хааны зарлиг, далай Чүнхүр, Сэнгэ мэргэн Хошиунчид илгээв. Та бүгдээр хэлэлцэж, Уяад (Урад)-д элч илгээ. Иханчи ирэх. Үл ирэхүйг лавт үг Хянх (Хянгaн) шахаж ирснийг илжгийн хэгүхэд /хүүхэд/ залайд муу үг хэлж, хойш харив хэмээн яаруу илгээв” гэв (Ли Бу Вен, 1996). Энэ зарлиг нь манжийн хаан Тэнгэрийн Цэцний тавдугаар оны долоон сарын тавны /1631.8.2/ өдөр илгээсэн захидал болно. Хунтайжийн энэхүү бичгээс үзвэл тэр үе Илжиг Зоригтын хөвгүүд ба Жалайд аймаг нэгэнтээ Нун мөрний араар нутаглаж байсан бөгөөд Ар Хорчин аймаг, Дөрвөн хүүхдийн аймаг нь нэгэнтээ Айшин гүрнийг дагасан байжээ.

Тэнгэрийн Цэцний долдугаар оны /1633 он/ таван сараас найман сарын хооронд Урад аймгийн тайж Түмэн дархан, Хайс баатар, Гүмбэ, Эрх, Сэнгэ, Сунидай, Авгалдай, Өвгөн тайж нар урд, хойно морь тэмээ өргөж, хойд Алтан улсыг түшив. Тухайн үед Урадын гурван аймгийн ахлагч тайж Түмэн дархан бол Бурхайн их хөвгүүн Лайгаан нь Урадын нэг аймгийн ахлагч. Хашбутулу бол Барсайн омбол Төвийн хөвгүүн Урадын нэг аймгийн ахлагч, Өвгөн тайж Барсайн хоёрдугаар хөвүүн Ханьсчингийн омбол Урад аймгийн бас нэг ахлагч. Урад аймаг жинхэнээр хойд Алтан улсыг түшжээ.

1636 оны 10 дугаар сард Чин улсын засгийн ордон Монголын эл хошуу аймгийг өрх ам дансалж, хуваарилсан байна. Урад аймгийн Дувын харьяат 750 өрх, 14 ниру Сайлангийн харьяат 390 өрх, 8 ниру, Өвгөн тайжийн харьяат 750 өрх, 15 ниру хуваарилжээ. Урад аймаг нь нийт 1890 өрх, 37 ниру, нэг өрхөд таван ам гэж бодвол нийт 9450 хүн амтай өөрөөр хэлбэл, тухайн үеийн Урад аймгийн хүн амын тоо нь бараг нэг түм орчим

байсан байна (齐木, 2006). Дээрхээс Урад аймаг нь нэгэнтээ дотроо гурван хэсэг болж тусгаарлаж, тус тусын ахлагч ба тогтсон өрхтэй байжээ. Энэ нь Урадын гурван хошууны анхны бүрэлдэл мөн. Тухайн үед хошууны зааг шугам гэж ялгагдаггүй учраас хэл яриа, зан заншлын зөрөө байхгүй. Айшин гүрэнг түшсэний дараа тэдэнд тусгай нутаг зааж өгсөнгүй. Харин Муумянганг Дөрвөн хүүхэд, Заруудад дагуулан, Урадыг Дөрвөн хүүхэдэд дагуулжээ (Иүй Жи, 2008). Үүнээс өмнө арын монгол аймгийн Онгинууд, Ар хорчин нь Тэнгэрийн Цэцний дөрөвдүгээр оны /1630 он/ 3 дугаар сард, Дөрвөн хүүхэд, Исүүд аймаг нь 11 дүгээр сард нэгэнтээ Айшин гүрнийг түшиж, их Хянган давааны өмнө бие Шар мөрний хойд хөвөөгөөр нүүдэллэн ирж нутаглажээ. Энэ үеийн Нун хорчин аймгийн нүүдэл нутаг нь зүүн хойш Дагуур үндэстний суугаал оронтой хөршилж, зүүн талаараа Сунгари мөрнөөр зааглаж, баруун талаараа Арын монгол аймагтай залгагдаж байжээ (齐木, х.294).

1636 оны 4 дүгээр сард говийн өмнөх монголын 16 аймгийн 49 феодал эзэд Мүгдэн хотноо чуулж, манжийн Дайзун хаан хунтайжийг “Богд цэцэн хаан” хэмээн өргөмжилж, Чин улсыг байгуулан, оны цолоо Дээд эрдэмтийн анхдугаар он гэж, үндэстний нэрээ манж үндэстэн гэж өөрчилжээ. Хунтайж манж, монголын их хаан болсон байна. Тус жилийн сүүлчээс эхлэн Чин улсын засгийн газрын дайчилгаанаар Арын эл аймаг даруй Урад, Дөрвөн хүүхэд, Архорчин зэрэг их аймаг Мин улс, Солонгос, халхыг дайлах дайнд оролцож гавьяа байгуулжээ. Урад аймгийн дайнд оролцсон байдлыг доор дөхөм жагсаавал: 1636 онд Сэрэнгийн харьяат Шангин зарлигаар Солонгост бичиг хүргэх замдаа Мин улсын Пай Доу аралд шархдаад буцсанд хүнд шан хүртэв. Урадын Өбэн, Дуба нар манж хааныг дагаж, Солонгос улсыг дайлав. Сэрэн нас барав. 1637 оны хаврын тэргүүн сард Дуба 200 цэрэг дагуулж, Варга аймгийг дайчилж, Солонгосын өмөг цэргийг Жиин Мү Хайн газар дарав. 1638 онд Солонгосоос буцан ирээд Дубагын хөвгүүн Цогтбөх, Тоху /тогоо/ аварга Сангарч, Бандитан лугаа нийлж, халхыг дарахаар Хөх хот орчим очив. 1639 онд хааныг дагаж, Мин улсын Сүн шаныг дайлаар дайнд тэргүүлж явав. 1641 онд Урад цэрэг Мин улсын Хэмэрлэг хот Жинчеүг дайлахад хошуучилж гавьяа байгуулав. 1642 онд Урадын цэрэг Цагаан хэрмийг давж, Жий Жеуг байлдан эзлэв. Энэ дайнд гавшгайлан орж, гавьяа байгуулсан тул манжийн хаанаас Урадын ноёдыг алт, мөнгө, торго, бүсээр шагнав. Тайж Дубад “Улаан тайж” хэмээх цол өгөв. 1646 онд Дуба, Өбэн, Багваахай нар манжийн цэрэгт хошуучилж, Сөнөдийн Тэнгис вангийн бослогыг дарав. 1647 онд Урад аймгийн цэрэг нь манжийн цэрэгт хошуучилж, Заж булгийн эхэнд Халхын Түшээт хан аймаг ба Цэцэн хан аймгийн 5 түмэн

холбоот цэрэгтэй байлдаж, халх цэргийг дарав (Бөхчулуу, 2010, х.129)

Эеэр засагчийн 5-р он (1648)-д гавьяаг ялган тоочих үед Омбу болон Сэрэн нэгэнтээ нас барсан тул Дубыг засаг, улсын түшээ гүн өргөмжилж, хойд хошуу (бас баруун хошуу гэдэг)-г захируулж, Омбугийн хүү Өбэнг мөн засаг, улсын түшээ гүн өргөмжилж, өмнө хошууг (бас зүүн хошуу гэдэг) захируулж, Сэрэнгийн хүү Багваахайг засаг, улсын туслагч гүн өргөмжилж, дунд хошууг захируулан цөм засаг болгоод, Хөндлөн, Хадмал, Монын хошуу зэрэг гурван сүвийг сахиулан суулгав (Чойжигав, х.27). Урадын гурван хошууг Мона уулын ар, өврөөр нүүлгэсэн нь Халхын өмнөш дайлан довтлохыг сэргийлэхээс гадна монголчуудыг алс зайдуу суулгаж, хошуу чуулганы дүрмийг хэрэгжүүлэн, хүчийг нь салгах гэсэн бас нэг зорилго болно. Урадын гурван хошуу Мона уулын ар, өврөөр нүүдэллэн ирэхээс өмнө тус нутаг нь Түмэд аймгийн нутаг дэвсгэр байжээ. Түмэд аймаг нь Алтан хаанаас нааш хэдэн үе Мин улсын өргөмжлөлийг хүртэж, хожим нь Лигдэн хаанд эзлэгдэж, дараа нь манжийг дагав. Манж үсгийн материалын тэмдэглэл дэх манж гүрэн Лигдэн хааны гараас эндэх бэлчээр нутгийг булаан авч, Түмэд монголд буцаан соёрхож өгсний дараах “Хөх хотын Түмэд монголын бэлчээр нутгийн хэмжээ нь өмнө зүгт Шүрхэй хаалганы хилийн хэрэм тулж, умар зүгт Хадмал гол, зүүн зүгт Эрдэнэцагаан хүрээ, баруун зүгт Бугат балгасын баруун дахь Цагаан овоо хийгээд Хатан голд хүрнэ” гэсэн тэмдэглэл бол хэрэг дээрээ 1675 он (Энх-Амгалангийн 14 дүгээр он)-оос хойш Түмэдийн нутагт Урадын гурван гүнгийн хошуу, Дөрвөн хүүхэд, Дархан бэйл, Муумянган аймаг хийгээд Цахар найман хошууг нүүлгэн авчирч, гурван талаар нь шахан суурьшуулсны дараах газар шорооны хүрээ хэмжээг хэлж байгаа юм. Үүнээс өмнөх үеийн Түмэд аймгийн бэлчээр нутаг бол маш өргөн уудам байсан бөгөөд тухайн үед эндэх газар шороон дээрээс нэгэнтээ татварлан гаргасан “Аман тооны газар” хийгээд “Сүм хийдийн амин тэжээлийн газар” <<бас сүм хийдийн хүж зулын газар гэдэг>> -ыг гаргавал үлдсэн газар нь цөм олон нийтийн бэлчээрийн газар болох юм (Хөгжил, 2003, х.33). Иймээс Урад аймаг Мона уулын ар, өврөөр нүүдэллэн ирэх үед тухайн газарт Түмэд аймаг нүүдэллэн амьдарч байсныг мэдэж болно.

Гурав. Урад аман ярианд аймгийн нүүдлийн үзүүлсэн нөлөө

Нэг. Урад аймаг, Дөрвөн хүүхэд, Муумянган нь Хөлөн буйр нутгаас Шармөрний ойр хавьд нүүдэллэн ирэх явцад нь болсон соёлын аж амьдралын орчин ахуйгаас салсангүй. Монголчууд нь өнө удаан жил нүүдлийн мал аж ахуйг эрхлэн, аж төрсөөр ирсэн учир нутгийн аялгууны ялгаа нь

их бус бөгөөд аль хойно орших Сэлэнгийн буриад нар, Хатан голын цаана орших Ордосуудтай саадгүй харилцаж байсан байдаг (Төмөрцэрэн, 1983, х.781). Энэхүү нөхцөл байдал нь Урад аймаг, Дөрвөн хүүхэд, Муумянган хэл ярианд тийм их хувирал гарах боломж байсангүй.

Хоёр. Нүүдэллэсэн цаг нь Нун хорчин аймгаас бараг 100 жилийн хойно юм. Дөрвөн хүүхдийн аймаг нь 1630 онд Айшингүрнийг түшиж, Урад ба Муумянган нь 1633 онд Айшингүрнийг дагажээ. 1630 онд Шармөрний ойр хавьд нутаглаж байснаас 1648 онд Мона уулын эргэн тойронд нүүх хүртэлх 18 жилийн хугацаанд эдгээр гурван аймаг нь үндсэндээ хөрш зэргэлдээ нутаглаж, мөн мал аж ахуйгаа эрхэлж байсны зэрэгцээ Чин улсын төрд үргэлж шударгаар үйлчилж, Чин улсын төрийг бататгах дайн байлдаанд хамт оролцсон түүх байдаг. Нэг үндэстний соёлд үндсэн хувиралт гарах нь тэр үндэстний хэл ярианд хувиралт үүсэх чухал нөхцөл болно. Бас нэг нөхцөл шалтгаан гэвэл нэг үндэстэн нь дотор зуураа адил бус чиглэлийн нүүдэл буюу цаг хугацааны талаар хэтэрхий урт ба орон зайн хувьд алс зайдуу байрших нь хэл ярианд аялганы зөрөөг үүсгэнэ. Урад аймаг, Дөрвөн хүүхэд, Муумянган монголчууд нүүдэллэх явцдаа малжих соёлын орчин тойрноос салаагүй учраас хэл аялгууныхаа дотоод хөгжлийн жам хуулиа алдсангүй. Гэвч Мона уулын ар, өвөрт нүүдэллэж очсоны дараа Ордосын аман аялгуу, эзнээ-алшаа аман аялгуу, цахар аман аялгуу, халх аман аялгууны орчин тойронд хүрээлэгдэж, хэл аялгууны гадаад хүчний нөлөөг хүртэж, харилцан нөлөөлөх нь дамжиггүй билээ.

Судалгааг үндэслэвэл, Урад аман яриа нь Ордос аман аялгууны нөлөөг илүү хүртсэн нь илэрхий, халхыг сэргийлүүлэхээр орчуулсан учир халх аман аялгууны нөлөө нь шинэгэсэн, харьцангуй бага, харин Урадын хойд хошууны хил дагуух монголчуудад зохих хэмжээгээр нөлөөлсөн байна.

Дүгнэлт

Улаанцавын чуулган дахь халх баруун гарын хошууг эс тооцвол бусад таван хошуу (аймаг) бүр нь Хөлөн буйрт нутаглан амьдарч байснаа нүүдэллэн шилжиж ирсэн Чингис хааны дүү Хавт Хасарын хойч үе тул хэдийгээр аймаг хошуу нь ондоо болон хуваагдсан боловч тэдний үг яриа, үйл ажиллагаа, шашин шүтлэг, амьдралын зан заншил зэрэг нь үндсэндээ адил байдаг юм (Чинлүн, 2005, х.3). Гэвч Чин улсаас хэрэгжүүлсэн чуулганы дүрэм ба хэсэглэн салгах төрийн бодлого нь чуулган хоорондоо буюу хошуу хоорондоо чөлөөтэй харьцахыг цаазалдаг. Дөрвөн хүүхдийн аймаг, Муумянган, Дархан бэйлийн нэг хошуу(халх баруун гар) жич, Урадын гурван хошуу зэрэг зургаан хошууг Улаанцавын чуулганд багтааж байсан ч хошуу хоорондоо чөлөөтэй

харьцаж болдоггүй байжээ. Иймээс хошуу бүрийн хэл яриа нь мөн өвөрмөц онцлогтой байдаг. Урадын гурван хошууны дундуур Мона уул хөндлөн оршдог болохоор зам харилцаа нэвтрэхэд нэн төвөгтэй төдийгүй Урадын өмнөд хошууны аман яриа нь Урадын дунд, хойд хошууны аман яриатай илт зөрөөтэй байдаг зэрэг нь дээр дурьдах нөхцөд байдлуудаас шалтгаалсан байж болох талтай.

Ашигласан материал

- Хурц. (2001). Чэн Мин: “Хорчин товчоо”, Үндэстний хэвлэлийн хороо, х.13, 36, 37, 49, 129, 191, 76. Хөххот
- “Хар Татаарын хэргийн товч”, “Өвөрмонголын түүхэн тойм”-оос дам ишлэв, х.91. Өвөрмонголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 《元史》第六册, 表传, 明宋濂等撰, 中华是书局, 2710页
- “Зарлигаар тогтоосон гадаад Монгол хотон аймгийн ван гүнгийн илтгэл шастир”, 41-р боть
- Ваанжил. (1989, 6 сар). Гурван Урадын Монад ирсэн он жилийг тодорхойлох нь, “Өвөрмонголын нийгмийн шинжлэх ухаан”. Хөх хот
- Ли Бу Вен. (1996, 1 сар). Намка: “17-р зууны эхэнд холбогдох дөчин гурван хувь монгол бичиг. “Өвөрмонголын нийгмийн шинжлэх ухаан. Хөх хот
- 齐木德道尔吉: “乌拉忒都迁徙考”, 《中央民族大学学报》, 2006年第三期
- Иүй Жи. (2008, 3 сар). Нун хорчин Шар мөрний хавьд нүүж нутагласан тухай. Өвөрмонголын Их Сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. Хөх хот
- 齐木德道尔吉: 《四子都落迁徙考》, 《蒙古史研究》, 第7期, 294页
- Бөхчулуу, Г. (2010). Урад аймгийн түүхэн дэх чухал хэрэг учрын хэлхээс”. “Урад судлал”. Хөх хот: Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо.
- Чойжигав. “Урадын гурван гүнгийн хошууны түүхэн сурвалж”. Баяннуурын түүхийн материал /7/, 27-р нүүр
- Хөгжил, Ч. (2003). “Манж Чин улсын үеийн Хөххотын Түмэд орны газар шорооны асуудал”, Хөх хот: Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо
- Төмөрцэрэн, Ж. (1983). “Монгол хэлний үгийн сангийн судлал”. “Орчин “цагийн монгол хэл”. Хөх хот: Өвөрмонголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо
- Чинлүн, Ш. (2005). Улаанцав чуулганы монголчуудын зан үйлийн дурсамж. Хөх хот: Өвөрмонголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо